

Бүлэг: 2 “Хувь хүн ба соёл”  
Сэдэв: Бид үндэстнийхээ соёлоор  
бахардаг

Хамрах хүрээ: 9 анги

УЛААНБААТАР

2021

Багш: З.Цэвэгмиджав

## Хичээлийн зорилго

- ❑ Өөрийн улс орон, үндэстнийхээ соёлын өвөрмөц байдал, мөн чанарыг танин мэдэж, түүгээр бахархах хүндэтгэх

Эхлээд бүгдээрээ доорх асуултуудад өөрийн бодлоор хариулна уу.

- Хувь хүн гэж хэн бэ?
- Соёл гэж юу вэ?
- Соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

**Соёл** гэж хүний байнгын, идэвхтэй, чөлөөт үйл ажиллагааны үр дүнд бий болж уламжлагдаж байдаг хэм хэмжээ, итгэл үнэмшил, билэг тэмдэг, үнэт зүйлсийн цогц, хүний хөгжсөн түвшин юм.

**Өөрөөр хэлбэл соёл нь хүний ололт амжилтын цогц.**

**Хувь хүн гэдэг нь: Өөрийн гэсэн бие  
бялдар, оюун ухаан, зүрх сэтгэл, итгэл үнэмшилтэй  
дахин давтагдашгүй бодгаль юм.**

# Хувь хүний соёл

Тухайн нийгэмд биеэ авч явах байдал. Үүнд дараах зүйлс орно.

- ✓ Харилцаа
- ✓ Амьдралын хэв маяг
- ✓ Хэл ярианы соёл
- ✓ Зан ариншин
- ✓ Хүмүүжил
- ✓ Хувцаслалт

Хувь хүний соёлын түвшин тухайн хүний ёс суртахуунаас хамаарна.

# Сэдэв: Бид үндэстнийхээ соёлоор бахардаг

- Аливаа улс үндэстний соёл хэрэглэгдэж байж урт удаан хугацаанд өвлөгдөн үлддэг. Тухайлбал: Монголчууд баяр наадам хийж, үндэстний дээл хувцасаа өмсөж, дуугаа дуулж, бүжгээ бүжиглэж, тоглоом наадгайгаараа нааддаг уламжлалтай, эх хэл бичгийн боловсрол олгодог. Эдгээр соёлын тухай мэдлэг, хэрэглээ үнэ цэн нь “Би монгол хүн” гэх бахархах эх үндэс нь болж байдаг.

Өөрөөр хэлбэл: Урт удаан хугацаанд тээсээр ирсэн ёс заншил нь бүхэлдээ “Монгол хүн гэж хэн бэ?” гэх асуултанд хариу олох боломжийг бүрдүүлж өгдөг.

Хүн бүхэн тодорхой нэг үндэстний төлөөлөл.

Бусад үндэстнээс ялгарч буй хэв шинж, өвөрмөц эрхэм бүхнээрээ үндэстэн бүр бахархдаг бас эвлэлдэн нэгдэж байдаг.

Мөн монгол хүн бүхний бахархдаг үнэт зүйл (соёл)бол **ёс заншил** юм. Иймээс ёс заншилийн талаар дэлгэрүүлэн тайлбарлая.



# Ёс заншил

Ёс заншил бол тухайн ард түмэнтэй хамт үүсэж, үндэстнийхээ олон зууны туршлагыг хуримтлуулах, хадгалах, хойч үедээ өвлүүлэх өвөрмөц арга юм.



# Ёс заншил нийгмийн амьдралын бүх талыг хамарна.

## Оюун санааны амьдралд

Баяр ёслол, хурим найрын ёс дэг, ураг төрлөө мэдэх, өвөг дээдсээ хүндэтгэх, газар ус, ургамал модоо хайрлах...

## Нийгэм, улс төрийн амьдралд

Монгол улсын ерөнхийлөгчийн тангараг өргөх, төрийн их цагаан тугийг залах хүндэтгэх

## Эдийн засгийн амьдралд

Нүүдэлчин амьдрал, аж ахуйг эрхлэх арга ухаан ...

Ёс заншил нийгмийн амьдралын бүх талыг хамарна.

- Өөрөөр хэлбэл нийгмийн амьдралыг зохицуулагч гол арга хэрэгсэл болох эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээний эх сурвалж болдог

Эрх зүйн хэм хэмжээ болох хууль, дүүрм журам бол: Тухайн хүнийг хүссэн хүсээгүй захирагдахыг шаарддаг, заавал дагаж биелүүлэх ёстой байдаг.

Ёс суртахууны хэм хэмжээ нь: Чиний итгэл үнэмшил юуг шаардаж байна түүнийхээ дагуу хийхийг шаардна.

# Үндэстний соёл гэж юу вэ?

Тухайн улс үндэстний нийтийн хүртээл болсон итгэл үнэмшил, зан байдлын хэв маяг үнэлэмжийн нэгдлийн хэлнэ.



# Өвлөж авч үлдэж буй ёс заншил, уламжлалт зан үйлийн 2015 оны судалгаатай танилцана уу?

## Судалгаа





Соёлын өвийг биет болон биет бус гэж  
ангилдаг.

# Соёлын өв

- ❑ **Биет соёлын өв:** Түүхэн тодорхой орон зай цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа зүйлсийг хэлнэ. Тухайлбал: Хадны бичээс, үлэг гүрвэлийн яс өндөг, хиргисүүр, хөшөө дурсгал...





**Биет бус соёл:** Тухайн ард түмэн, үндэстний оюун санаагаар бүтэж, уламжлагдан ирсэн түүхэн тодорхой орон зайг төлөөлж чадах эх хэл, ардын мэдлэг, амьдрах арга ухаан, байгаль ертөнцийн тухай мэдлэг, хөдөлмөрийн зан үйл, наадам наргиа, ёс заншил, дуу хөгжим, уламжлалт гар урлал, түүний ур хийц, технологи зэрэг.





Монгол түмэн өөрсдийн эх орон, газар шороо, тусгаар тогтнол, эх түүхээрээ бахархдаг. Иймээс ч өнөөгийн даяаршиж буй нийгэмд эх хэл соёлоо устаж үгүй болохоос хамгаалж судалгаа шинжилгээ хийж, хойч үедээ өвлүүлэхийг зорьж биет болон биет бус өвийн судалгааг хийдэг.

## Дасгал ажил:

- ❑ Археологийн судалгаа гэж юу вэ? (Биет өвийн судалгаа)
- ❑ Аман түүх гэж юу вэ? (Биет бус өвийн судалгаа)
- ❑ Дэвтэрт тэмдэглэн хариулах: Хамгийн түрүүнд илгээсэн 5 сурагч нэмэлт оноотой



# ДүГНЭЛТ:

Ёс заншил бол тухайн үндэстний эрхэмлэх зүйл, хэрхэн яаж ухаалгаар амьдрах тухай үзэл төсөөлөл.

Монгол соёлын үнэт зүйлс болох:

- Билэг тэмдэг
- Ардын урлаг
- Эх хэл, соёл, бичиг, үсэг
- Ардын аман зохиол
- Зан заншил
- Ном, судар, зохиол
- Гар урлал, угийн бичиг
- Хадны зураг, бичээс зэргийг судалж танин мэдэж, мэдлэгээ бусадтай хуваалцаж байх нь чухал юм.

# Гэрийн даалгавар:

- Сурах бичиг: хуудас-32 (нэгийг нь сонгоод хийж мэдлэгээ баталгаажуулаарай)